



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хаан палас ХХК-ны "Кемпински" зочид буудлын 16/019, Нэгдэлч ХХК-ны "Нэгдэлчин" зочид буудлын 14/24, Их алтай ХХК-ны "Номуун далай" зочид буудлын 13/222, Сэрг уул ХХК-ны "Алтан цайз-1" дэн буудлын 13/251, Хонгор экспедишин ХХК "Хонгор" дэн буудлын 15/031, Трикларс треже ХХК-ны "Гурван өнгө" дэн буудлын 14/36 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсувд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 05 сарын 31
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Их Алтай ХХК	2565595	Номуун далай	БГД-ийн 19-р хороо Хасбаатарын гудамж-21/16
2	Нэгдэлч ХХК	2095688	Нэгдэлчин	БЗД-ийн 6-р хороо 31/1
3	Хаан палас ХХК	2873877	Кемпински	БЗД-ийн 4-р хороо Их тойруу-178
4	MMC Поларис ХХК	5893003	Ибис стайлс	ХУД-ийн 2-р хороо Үйлдвэр-Чингисийн өргөн чөлөө-81

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 05 сарын 21
өдрийн АЖАА дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сэргүүл ХХК	2657112	Алтан цайз-1	БЗД-ийн 22-р хороо Өлгийн 10-154
2	Хонгор экспедишин ХХК	2582627	Хонгор	ЧД-ийн 3-р хороо 50.000-ын 15/5
3	Фосийзн тур ХХК	5170907	Фосийзн	ЧД-ийн 2-р хороо 50.000-ын 25/14
4	Трикларс Треже ХХК	5513367	Гурван өнгө	БГД-ийн 6-р хороо ААӨЧ-76/12

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 6. сарын 31
өдрийн 11:17 дугаар тушаалын
туравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Өндөр улаан трэвэл ХХК	2782111	Ред рок ресорт	НД-ийн 6-р хороо

--ooOoo--